



**МОНГОЛ-ОРОСЫН  
ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН НИЙГЭМЛЭГ  
УЛААНБААТАР ТӨМӨР ЗАМЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 09 сарын 18 өдөр

Дугаар A/820

Улаанбаатар хот

Г Тариф шинэчлэн батлах тухай Г

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-ын дүрмийн 22 дугаар зүйлийн "а" заалт, 2021 оны үйлдвэрлэл, санхүү-аж ахуйн үйл ажиллагаанд хийсэн шалгалтын зөвлөмжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийгэмлэгийн өөрийн өмчийн үл хөдлөх хөрөнгийг түрээслүүлэх журмыг 1 дүгээр хавсралт, үл хөдлөх хөрөнгийг хуулийн этгээд болон иргэнд түрээслүүлэх төлбөрийн хэмжээ (тариф)-г 2 дугаар хавсралтаар тус тус баталж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөн ажиллахыг баланстай бүх алба, төв, хэлтэс, тасгийн дарга нарт үүрэг болгосугай.

2. Тушаалыг хэрэгжүүлэхтэй холбоотой зааварчилгааг ажилтнуудад өгч ажиллахыг Төлөвлөлт, эдийн засгийн албаны дарга (З.Энхбаяр), Хууль зүйн албаны дарга (Яковенко Е.Р), Дотоод аудит, хяналт шалгалтын албаны дарга (А.Энхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан 2022 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/775 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

4. Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засаг, санхүү хариуцсан замын орлогч дарга бөгөөд Санхүү, нягтлан бодох бүртгэлийн албаны дарга (Усольцева С.Я)-д даалгасугай.

НЭГДҮГЭЭР ОРЛОГЧ ДАРГА



О.А. КАЗАКОВ

1601235006